



БАЯНХОНГОР АЙМАГ
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 23 өдөр

Дугаар А/66

Хөхбүрд

Усалгааны систем суурилуулах ажлыг
хүлээлцэх ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн усалгааны систем суурилуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан, хүлээж авах ажлыг зохион байгуулсугай.

2.Ажил хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Ганцоож (Засаг даргын орлогч)

Гишүүд: Д.Отгонцэцэг (Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)

П.Мөнхтогоо (Байгаль орчны улсын хяналтын улсын
байцаагч)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

Л.Алимаа (Нягтлан бодогч)

П.Батцэцэг (Нярав)

М.Ганбаатар (Байгаль хамгаалагч)

3."Усалгааны систем суурилуулах" ажлыг нэг бүрчлэн хариуцлагатай чанартай хийгдсэн эсэхэд шалгалт хийж ажлын талаарх шаардлагатай тэмдэглэл, фото зургийг илтгэх хуудасны хамт гүйцэтгэгч компаниар албажуулж, тайланд хавсаргахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (М.Жавзансүрэн)д үүрэг болгосугай.

ДАРГА Г.ОРХОНТУУЛ



642301187